

ЭМГ-ЫН 9 ДҮГЭЭР 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

Нэг. Зарим статистик үзүүлэлт

Нийт төрөлт - 58
Амьд төрөлт - 57
Амьгүй төрөлт - 1
Дутуу төрөлт - 0
Нялхсын эндэгдэл - 0
28 хоногоос 1 нас хүртэлх эндэгдэл - 0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл - 0
Эхийн ноцтой хүндрэл - 0
Төрөлхийн гажиг - 1
Гэрийн төрөлт - 0

Хоёр. Томуу, томуу төст өвчин

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 08 дугаар долоо хоногт нийт 4539 хүн үйлчлүүлсний 419 буюу 9.2% нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.4%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэдийн 22.3%-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 0.7%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна. Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 560 дуудлагын 182 буюу 32.5%-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 7.6%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Гурав.

Зөвлөгөөн зохион байгуулагдлаа

- Аймгийн Эрүүл мэндийн газар 03 дугаар сарын 06-ны өдөр эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны аймгийн зөвлөгөөнийг “Инээмсэглэл – эерэг хандлага” сэдвээр амжилттай зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд аймгийн Засаг дарга А.Гылымхан, аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга К.Бекжан, тус хэлтсийн эрүүл мэндийн түшмэл К.Амалхан болон сумдын Засаг дарга нар, сум, тосгон, баг, өрхийн ЭМТ, сум дундын эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сансар эмнэлэг, ЗӨСТ-ийн дарга, эрхлэгч нар, Эм холбооны тэргүүн, ЭМГ-ын дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд зэрэг нийт 60 гаруй хүн оролцлоо. ЭМЯ-наас 2019 оныг эрүүл мэндийн салбарын ажилтнуудын ёс зүй, харилцааны соёлыг улам дээшлүүлэх зорилгоор “Инээмсэглэл – эерэг хандлага” уриаг дэвшүүлсэн юм. Аймгийн эрүүл мэндийн салбарт маш их хэмжээний хөрөнгө оруулалтууд хийгдэж, эмч, мэргэжилтнүүдийг сургаж, чадавхжуулахад аймгаас анхааран ажиллаж байгаа

бөгөөд цаашид эмч, мэргэжилтнүүд харьцаа хандлага, ажлын хариуцлагыг дээшлүүлэн ажиллах шаардлагатай байгаа тухай зөвлөгөөний нээлтийн үеэр аймгийн Засаг дарга А.Гылымхан хэлсэн үгэндээ онцолж байв.

Зөвлөгөөнд 2018 онд улсын хэмжээнд болон аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт хийгдсэн томоохон ажлууд, хүрсэн амжилтууд болон цаашид хамтран шийдвэрлэх тулгамдсан асуудлуудын талаар 9 мэдээлэл хийгдэж, оролцогчдын саналыг сонсож, асуултанд хариулав.

2018 оны ажлын гүйцэтгэлээр эхний байр эзэлсэн хамт олон, дарга нарыг шагнаснаар зөвлөгөөн өндөрлөв.

Сумдаас Толбо сумын ЭМТ 1 дүгээр байр, Алтанцөгц сумын ЭМТ 2 дугар байр, Ногооннуур сумын СДЭ 3 дугаар байр, өрхийн ЭМТ-үүдээс Жансая өрхийн ЭМТ 1 дүгээр байрыг тус тус эзлэв.

2018 оны “Онцгой амжилт гаргасан” номинацид аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх тасаг, “Манлайлагч менежер” номинацид Баяннуур сумын ЭМТ-ийн эрхлэгчээр ажиллаж байгаад 2018 онд тэтгэвэр гарсан ахмад эмч А.Бейбит, Шипагер өрхийн ЭМТ-ийн дарга М.Алмагүл нар шалгарч, шагнагдав.

- 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 2 дугаар бүрэн дунд сургуулийн 5,6,7,8,9,10,11,12 дугаар ангийн нийт 775 сурагчдад “Ариун цэвэр ба эрүүл мэнд”, “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Ухаалаг утас, дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлье”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Бөөстөх өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Амны хөндийн эрүүл мэнд ба шүдээ хэрхэн хамгаалах” “Охид, хөвгүүдийн хүмүүжил”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Өсвөр насныханд тулгамдаж буй эрүүл мэндийн асуудлууд”, “Охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлье”, “Үр хөндөлтөөс урьдчилан сэргийлье” талаар сургалтыг явуулж, хүүхдүүдэд эерэг хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагаа зохион байгууллаа.
- “Сонсголоо шалгууль” сэдэвт өдөрлөг зохион байгууллаа. Эрүүл мэндийн газар, Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2019 оны 03 дугаар сарын -4 -ны өдөр “Сонсголоо шалгууль” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр НЭМТ-ийн мэргэжилтнүүд, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн чих хамар хоолойн тасгийн хамт олон эмчийн үзлэг оношлогоо, зөвөлгөө өгч, гарын авлага тарааж 100-аад иргэнийг хамрууллаа. Цаашид сургууль, албан байгуулагуудад үзлэг, оношлогоо, сургалтууд зохион байгуулах 7 хоногийн аянг хэрэгжүүлж байна. ДЭМБ-аас жил бүрийн 3 дугаар сарын 3-ныг дэлхий нийтээр чих, сонсголоо хамгаалах өдөр болгон зарладаг бөгөөд Монгол улс 2008 оноос эхлэн энэ өдрийг тасралтгүй тэмдэглэн ирж байгаа билээ. Энэ онд ДЭМБ-ээс дэвшүүлсэн “Сонсголоо шалгууль” уриан дор аймгийн хэмжээнд өргөн хүрээтэй зохион байгуулж байна. Та ирээдүйг сонсохын тулд одооноос сонсголоо хамгаалцгаая гэсэн уриаг Эрүүл мэндийн газраас дэвшүүлж байна.
- “Сэтгэлд шингэсэн сувилахуйн тусламж” сэдэвт 2 багц цагийн сургалт зохион байгуулагдаж, 150 гаруй сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан. Дотрын сувилагчдын нийгэмлэгээс Алтай сумын ЭМТөвд сувилагчийн тэргэнцэр, пульсоксиметр гардуулав.

- “ХОГ ХАЯГДАЛ БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД НӨЛӨӨЛӨХ НЬ” сэдэвт илтгэл тавигдлаа.

Мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан “Өлгий сумын ариун цэвэр, эрүүл ахуйн тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд Х.Дауыржан, Т.Рахат нар оролцож, Мэргэжлийн хяналтын газар, ЗДТГ-ын холбогдох хэлтэс, Өлгий сумын Засаг даргын тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хот тохижуулах алба, Өлгий сумын 13 багийн Засаг дарга, Ахдам, Тирлик зах, Малын захын төлөөллүүд болох нийт 30 албан хаагч нарт “ХОГ ХАЯГДАЛ БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД НӨЛӨӨЛӨХ НЬ” сэдвээр илтгэл тавьж , орчны эрүүл мэндэд дэмжлэгт хяналт хийх , нэг сарын аянг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
- Эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдол, амилуулах суурь тусламж, гэмтлийн үеийн суурь тусламж сэдэвт сургалт зохион явууллаа. 2019 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Х.Арай, Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч А.Хуаныш, гэмтлийн эмч Н.Маргулан нартай хамтран Цагааннуур тосгоны Хилийн цэргийн 0285 дугаар ангийн албан хаагчдад эрт илрүүлгийн ач холбогдол, амилуулах суурь тусламж, гэмтлийн үеийн суурь тусламж сэдэвт сургалт явуулж, гардан үйлдлийг 18 хүнд хийлгэж дадлагажууллаа.
- Биеийн жингийн индексээ тодорхойлуулах үйл ажиллагаа зохион байгууллаа. Эрүүл мэндийн салбарын Удирдах ажилтны зөвлөгөөнд Нийгмийн эрүүл мэндийн төвөөс Биеийн жингийн индексийн үзүүлэлт болон биеийн найрлагыг тодорхойлох үйл ажиллагааг зохион байгууллаа. БЖИ-ийн үзүүлэлт болон биеийн найрлагыг тодорхойлох аппаратанд оролцогчдоос 42 хүнийг хамруулан тухайн хүний жин, өөх тос, уураг, булчин, давс усны хэмжээ, бодисын солилцооны идэвхжил, биологийн насыг тодорхойлж оролцогч тус бүрт НБТЧ-ийн арга зүйч Ж.Цэндсүрэн мэргэжлийн арга зүйн зөвөлгөө өгч, ажилласан. Мөн хамрагдсан 42 хүнээс хэвийн жинтэй 17, илүүдэл жинтэй 10, таргалалтын 1-р зэрэгтэй 12, таргалалтын 2-р зэрэгтэй 2, таргалалтын 3-р зэрэгтэй 1 гэсэн үзүүлэлтүүдийг танилцуулж, мэдээлэл өгсөн. Дүгнэж үзэхэд хүмүүсийн өөх тос, уурагны хэрэглээ их, усны түвшин бага байгаад анхаарах , цаашид усны хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Харин хүмүүсийн давсны хэрэглээ буурсан үзүүлэлтэй гарч байгаа нь НЭМТ-ийн эмч мэргэжилтнүүдийн давсны хэрэглээний сургалт сурталчилгааны үр дүн , ЗГ-ын 353 тогтоолоор батлагдсан Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратегийн хэрэгжилт орон нутагт сайн байгааг харуулж байна.
- 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төв нь аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтарч аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 21 ажилтан, албан хаагчдад Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ, Сайн дурын зөвлөгөө шинжилгээний кабинетийн талаар, бэлгэвч хэрэглэх заавар, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдол, сүрьеэ өвчнөөс хэрхэн сэргийлэх чиглэлээр сургалтыг ЭМГ-ын Сүрьеэ, БЗДХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Ахтилек, АНЭ-ийн Сайн дурын зөвлөгөө шинжилгээний кабинетийн зөвлөгч А.Майка нар явуулж, 21 албан

хаагчийг ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх хурдавчилсан шинжилгээнд хамруулахад эерэг тохиолдол илрээгүй болно.